АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Архангай аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2026/005/-НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор Л.Соёлмөнх<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.23 № 154

танай ______-ны № ______-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.АДЪЯАСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,586,043.8 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,916,983.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 17 үндсэн зорилтын хүрээнд 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс **67.6** хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,410,752.09** | **3,724,318.39** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 970,596.01 | 3,325,360.07 |
| 33 | АВЛАГА | 351,820.40 | 258,768.23 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 88,335.68 | 140,190.10 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,965,248.93** | **2,646,935.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,965,248.93** | **2,646,935.70** |
| 39200 | Биет хөрөнгө | 2,925,361.93 | 2,628,763.70 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 39,887.00 | 18,172.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,376,001.02** | **6,371,254.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **4,482.73** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **4,482.73** |
| 41300 | Өглөг | - | 4,482.73 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,376,001.02** | **6,366,771.36** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,376,001.02** | **6,366,771.36** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 527,026.42 | 527,026.42 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **3,616,764.19** | **5,607,758.13** |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 232,210.40 | 231,986.81 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,376,001.02** | **6,371,254.09** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,674,263.20** | **4,314,564.83** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **988,152.75** | **1,034,973.89** |
| 110 | Орлогын албан татвар | 644,992.99 | 634,233.41 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 644,822.99 | 664,941.38 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | - | (30,839.97) |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 170.00 | 132.00 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 77,954.74 | 103,120.92 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 265,205.02 | 297,619.56 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,641,924.82** | **3,279,590.95** |
| 120 | Тусламжийн орлого | - | 2,879,022.72 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,044,185.63** | **-** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,146,685.81** | **2,096,440.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,146,685.81** | **2,096,440.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,069,911.91** | **2,071,374.12** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 784,913.89 | 938,717.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,573.37 | 114,498.59 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 208,934.37 | 229,899.59 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 66,910.93 | 100,432.36 |
| 2105 | Нормативт зардал | - | 927.48 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 76,628.57 | 22,974.28 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,641.00 | 14,688.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 14,318.45 | 8,990.48 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 811,991.33 | 640,245.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **76,773.90** | **25,065.89** |

| | | | |
|---|---|---|---|
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,527,577.40** | **2,218,124.83** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **608,823.23** | **227,354.49** |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(608,823.23)** | **(227,354.49)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **918,754.17** | **1,990,770.35** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,394,797.48** | **4,277,960.01** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **988,152.75** | **1,034,973.89** |
| 110 | Орлогын албан татвар | 644,992.99 | 634,233.41 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | - | (30,839.97) |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 170.00 | 132.00 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 77,954.74 | 103,120.92 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 265,205.02 | 297,619.56 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 16,785.50 | 14,794.20 |
| 1181 | Газрын төлбөр | 83.07 | 173.19 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 248,336.44 | 282,652.17 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **362,459.10** | **3,242,986.12** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 362,459.10 | 189,888.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | **2,879,022.72** |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | **174,075.41** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,044,185.63** | **-** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,877,352.57** | **1,643,226.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,877,352.57** | **1,643,226.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,800,578.67** | **1,618,160.54** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 784,913.89 | 938,717.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,573.37 | 114,498.59 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 208,934.37 | 241,099.59 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 65,124.33 | 59,424.05 |
| 2105 | Норматив зардал | - | 2,733.48 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,504.35 | 23,428.28 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,641.00 | 14,688.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,218.45 | 9,110.48 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 539,668.91 | 214,460.58 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **76,773.90** | **25,065.89** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **517,444.91** | **2,634,733.58** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **886,244.83** | **219,969.53** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **886,244.83** | **219,969.53** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 886,244.83 | 219,969.53 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(866,244.83)** | **(219,969.53)** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **100,000.00** | **60,000.00** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(100,000.00)** | **(60,000.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(468,799.92)** | **2,354,764.06** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,439,395.93 | 970,596.01 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 970,596.01 | 3,325,360.07 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,431,209.11** | **3,431,209.11** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 26,037.74 | 26,037.74 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,457,246.85 | 3,457,246.85 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 918,754.17 | 918,754.17 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,376,001.02** | **4,376,001.02** |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **4,376,001.02** | **4,376,001.02** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 223.59 | 223.59 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,376,224.61 | 4,376,224.61 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (223.59) | (223.59) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 1,990,770.35 | 1,990,770.35 |
| **20** | **2025 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл** | **6,366,771.36** | **6,366,771.36** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **865,392.40** | **3,198,037.94** | **(2,332,645.54)** | **369.55** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **614,092.40** | **1,034,973.89** | **(420,881.49)** | **168.54** |
| 110 | Орлогын албан татвар | **502,396.00** | **634,233.41** | **(131,837.41)** | **126.24** |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 534,764.00 | 664,941.38 | (130,177.38) | 124.34 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (32,500.00) | (30,839.97) | (1,660.03) | 94.89 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар | 132.00 | 132.00 | - | 100.00 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | **67,939.00** | **103,120.92** | **(35,181.92)** | **151.78** |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | **43,757.40** | **297,619.56** | **(253,862.16)** | **680.16** |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 11,601.60 | 14,794.20 | (3,192.60) | 127.52 |
| 1181 | Газрын төлбөр | 574.00 | 173.19 | 400.81 | 30.17 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 31,581.80 | 282,652.17 | (251,070.37) | 894.98 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **251,300.00** | **2,163,064.05** | **(1,911,764.05)** | **860.75** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 251,300.00 | 2,163,064.05 | (1,911,764.05) | 860.75 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,586,043.80** | **1,916,983.58** | **669,060.22** | **74.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,039,321.60** | **1,641,324.06** | **397,997.54** | **80.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,004,426.60** | **1,616,585.91** | **387,840.69** | **80.65** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 937,467.00 | 938,717.50 | (1,250.50) | 100.13 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 117,070.30 | 114,498.59 | 2,571.71 | 97.80 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 298,553.10 | 241,099.59 | 57,453.51 | 80.76 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 68,822.20 | 59,124.05 | 9,698.16 | 85.91 |
| 2105 | Нормативт зардал | 10,750.00 | 2,733.48 | 8,016.52 | 25.43 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,137.80 | 24,738.28 | 9,399.53 | 72.47 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 20,000.00 | 14,688.00 | 5,312.00 | 73.44 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,210.50 | 7,725.85 | 20,484.65 | 27.39 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 489,415.70 | 213,260.58 | 276,155.12 | 43.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,895.00** | **24,738.15** | **10,156.85** | **70.89** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,895.00 | 24,738.15 | **10,156.85** | **70.89** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **302,153.80** | **215,659.53** | **86,494.28** | **71.37** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **244,568.40** | **60,000.00** | **184,568.40** | **24.53** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 970,596.01 | (970,596.01) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 3,325,360.07 | (3,325,360.07) | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2** | **2** | **-** | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **28** | **28** | **-** | **100.00** |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,979,388.41** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,979,388.41** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,884.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,884.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,884.63** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,384.63 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200.00 |
| **4** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **1,973,503.78** |
| **5** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **(1,973,503.78)** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй тул санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Залруулаагүй нийт **5,059.6** мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 5,059.6 мянган төгрөгийн ОНХС- болон орлоготой холбоотой зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн **5,059.6** мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн албаны хяналтын үр дүнтэй холбоотой санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын 20,011.6 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **25,071.2** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын дүн **29,093.0** мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Албан шаардлага

**3.1.1** Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч үйл ажиллагааны орлого 1,559.6 мянга, газрын дуудлага худалдааны орлого 500.0 мянга нийт 2,059.6 мянган төгрөгөөр тасарсан, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

**3.1.2** Сумын ИТХ-ын 2025 оны 21 дүгээр тогтоолоор "ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-д батлагдаагүй байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн Ямаатын харзны булгийн эхийг хамгаалах 3,000.0 мянган төгрөгийн ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4-т “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, 4.5-т “Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Зөрчлийг таслан зогсоож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүллээ.

**3.1.3.** ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системд иргэдийн санал, ИНХ-аас баталсан төслүүд, ажлын хэсгийн эрэмбэлсэн мэдээлэл болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 82,974.0 мянган төгрөгийн 8 арга хэмжээний явцын гүйцэтгэлийг оруулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2.1-т "Сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>**: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг УМС-д байршуулаагүй зөрчлийг арилгаж, мэдээллийг нөхөж байршуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орлоготой холбоотой | 1 | 2,059.6 | - | - | 1 | 2,059.6 | - | - | - | - | - | - |
| ОНХС-тай холбоотой | 2 | 3,000.0 | | | 2 | 3,000.0 | | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **3** | **5,059.6** | **-** | **-** | **3** | **5,059.6** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 1,947,176.0 | 1 | 1,947,176.0 | - | - | 1 | 1,947,176.0 | - | - | - | - |
| **НИЙТ ДҮН** | **1** | **1,947,176.0** | **1** | **1,947,176.0** | **-** | **-** | **1** | **1,947,176.0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ЗДТГ | 2 | 14,100.0 | - | - | 2 | 14,100.0 | - | - | - | - | - | - |
| ИТХ | 3 | 3,143.6 | 1 | 623.6 | 2 | 2,520.0 | - | - | - | - | - | - |
| ХХС | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| ЭМТ | 1 | 2,768.0 | 1 | 2,768.0 | | | | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **6** | **23,011.6** | **2** | **3,391.6** | **4** | **16,620.0** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |